



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 9-өөс
15-ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 9-15-ны байдлаар

КОВИД-19 вируст халдвар дэлхий нийтээр хурдтай тархаж, Пандемик (цар тахал)-ын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулах зорилгоор улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилготой долоо хоног тутмын гадаад орчны тойм мэдээллийн тав дахь дугаарыг хүргэж байгааг хүлээн авна уу.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

ОУВС-ийн 4-р сарын “Дэлхийн Эдийн Засгийн Төлөв” тайланд **дэлхийн эдийн засгийн өсөлт 2020 онд 3 хувиар агшиж**, 2021 онд 5.8 хувиар өсөх, КОВИД-19 вирусийн нөлөөгөөр дэлхийн эдийн засагт 2020 болон 2021 онд **9 их наяд ам.долларын хохирол** бий болох тооцоог хийжээ. Улс орнуудад энэхүү нөхцөл байдлын нөлөөгөөр эрэлт, нийлүүлэлтийн аль аль нь хумигдаж, хөгжингүй орнуудын эдийн засаг 2020 онд 6.1 хувиар агших бол хөгжиж буй орнуудын эдийн засаг 1 хувиар агшина гэж төсөөлжээ. “Great Lockdown” хэмээн нэрлэгдэж буй өнөөгийн хямрал нь 2008-09 оны санхүү, эдийн засгийн хямралаас илүү гүнзгий, 1930-аад оны Их хямралаас хойших эдийн засгийн хамгийн хурц хүндрэл байж болзошгүйг шинжээчид онцолж байна. ОУВС энэхүү суурь төсөөлөлдөө 1) Ихэнх улс орнууд цар тахлыг энэ оны II улиралд (Хятад улс I улиралд хяналтад оруулсан) хяналтад оруулж, оны 2 дугаар хагаст эдийн засаг сэргэнэ; 2) Улс орнуудад банк, санхүүгийн системийн тогтвортой байдал хадгалагдаж, ажилгүйдэл хэт ихээр нэмэгдэхгүй гэсэн таамаглалд үндэслэжээ.

Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд

	Эх сурвалж	Төсөөлөл хийсэн огноо	2020 он				
			Дэлхийн эдийн засгийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт
1	ОУВС	4/14/2020	-3.0%	1.2%	-5.9%	-7.5%	-5.5%
2	EIU	4/09/2020	-2.5%	1.0%	-2.9%	-6.0%	-2.6%
3	Oxford Economics	4/14/2020	-2.8%				

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

ОУВС-Дэлхийн банкны Хаврын уулзалтын үеэр ОУВС-ийн тэргүүн К.Георгиева 2020 онд дэлхийн 170 улсад нэг хүнд ногдох орлого буурахаар байгааг анхааруулав. ОУВС-аас **102 улс тусламж хүсээд байгаа бөгөөд 4-р сард 50%-ийг нь шийдвэрлэнэ** гэж мэдэгдэв.

■ ОУВС-ийн Төсвийн мониторинг (Fiscal Monitor) тайланд цар тахлын үеийн төсвийн бодлого эрүүл мэндийн салбарын санхүүжилтийг шийдвэрлэж, хүний амыг хамгаалах, эдийн засгийн зогсолтоос үүдэн санхүүгийн хохирол амссан иргэд, аж ахуйн нэгжүүдийг хамгаалах, мөн вирусийн дараах эдийн засгийн сэргэлтийг дэмжих нөөц төлөвлөгөөтэй байх нь чухал болохыг онцлов. Дэлхийн улс орнууд нийт \$8 их наяд буюу дэлхийн ДНБ-ий 9.5%-тай тэнцэх төсвийн дэмжлэгийн багцыг батлаад байна. Улмаар засгийн газруудын өрийн түвшин 13 нэгж хувиар нэмэгдэж, ДНБ-ий 96%-д хүрэхээр байна. КОВИД-19 вирусийн үеийн онцгой нөхцөл байдалд тохирсон онцгой төсвийн бодлогыг хэрэгжүүлэх нь чухал хэдий ч, сайн засаглал болон санхүүгийн сахилга бат, хариуцлага чухлыг мөн тус тайланд онцлов.

■ ОУВС-ийн Глобал санхүүгийн тогтвортой байдлын тайлан (Global Financial Stability Report)-д 1-р сартай харьцуулахад санхүүжилт авах нөхцөл илүү чангарсныг тэмдэглэв. Хувьцааны үнийн индексүүд унаж, бондуудын хүүний зөрүү (эрсдэлгүй бондын хүүтэй харьцуулснаар) нэмэгдэж, хөрөнгө оруулагчид эрсдэл багатай хөрөнгө оруулалт руу шилжих хандлага нэмэгдэж байна. Түүнчлэн хөгжсөн болон хөгжиж буй орнуудын хувьд гадаад валюттай харьцах ханшийн савлагаа өндөр, бодит үйлчилж буй ханш +/-20% дотор хэлбэлзэж байна. Хөгжиж буй орнуудаас гадагшлах хөрөнгийн урсгал 3 сарын дотор 100 тэрбум ам.доллар (ДНБ-ий 40%) буюу түүхэнд байгаагүй өндөр түвшинд хүрлээ. Холбооны нөөцийн банк (ХНБ) зэрэг гол төв банкууд 6 их наяд ам.долларын багцыг зарлаад байгаа нь хөрөнгө оруулагчдын ирээдүйн

төлөвийн талаарх хүлээлтийг тогтворжуулах нөлөөг үзүүлж байна.

■ ОУВС-ийн Бүс нутгийн төлөв: Ази, Номхон далайн орнууд (**Regional Outlook: Asia Pacific**) тайланд Ази, Номхон далайн орнуудын эдийн засгийн өсөлт 2020 онд 0 орчим байна гэж төсөөлжээ. Энэхүү өсөлтийн уналт нь Хойд Америк, Европтой харьцуулахад бага боловч, тус бүс нутгийн сүүлийн 60 жилийн өсөлтийн хамгийн доод түвшин байхаар байна. Бодит сектор, тэр дундаа үйлчилгээний салбар хурдтай саарсан, экспортод суурилсан Азийн эдийн засгуудын хувьд АНУ болон Евро бүс зэрэг гол худалдааны түншүүдийн эдийн засаг огцом саарч, Хятадын эдийн засгийн идэвхжил суларч байгаа нь бүс нутгийн эдийн засаг саарах гол шалтгаан гэж тайлбарлажээ. Олон улсын нөөцийн валюттай гол эдийн засгуудтай харьцуулахад тус бүс нутгийн **төсөв мөнгө, санхүүгийн бодлогын орон зай хязгаарлагдмал бөгөөд хөрөнгийн урсгал өндөр савлагаатай байгаа** нь эдийн засгийн тогтвортой байдалд эрсдэл учруулж байгааг онцолсон байна.

■ Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ) 4-р сарын тайландаа КОВИД-19-өөс үүдэлтэй эдийн засгийн хямралд Евро бүсийн болон ЕСБХБ-ийн үйл ажиллагаанд хамааралтай улс орнуудын эрүүл мэндийн систем, дотоодын эрэлт, нийлүүлэлт, гадаад шоконд дархлаатай байдал болон бодлогын орон зайны уян хатан байдлыг дүгнэжээ. Тухайлбал, дийлэнх орнуудад төсвийн бодлогын орон зай бага эсвэл дунд, **Төв Азийн орнууд түүхий эдийн үнэ, эрэлтийн шокод өртөх эрсдэл өндөр**, Төв Европын орнууд дэлхийн нийлүүлэлтийн сүлжээнээс хамаарал өндөртэй гэсэн бол Өмнөд Европын орнууд нэг хүнд

ногдох эрүүл мэндийн үйлчилгээний хангамж бага, хөдөлмөрийн зах нь шоконд өртөх эрсдэлтэй гэж дүгнэжээ.

- “КОВИД-19-ийн дэлхийн ДНБ болон дэлхийн худалдаанд үзүүлэх нөлөө” Дэлхийн банкны судалгааны тайланд¹ суурь төсөөллөөр хөдөлмөр, капиталын ашиглалт багасч, олон улсын гадаад худалдаа, аялал жуулчлал бууран, дотоод эрэлт саарах нөлөөгөөр КОВИД-19-ийн дэлхийн ДНБ-д үзүүлэх нөлөө -2 нэгж хувь байх, вирус хяналтад орох хугацаа удаашрах хувилбарт -4 нэгж хувьд хүрч болзошгүй гэжээ.
- АНУ-д ажилгүйдэл үргэлжлэн өсч, төсвийн алдагдал тэлж байна. АНУ-д сүүлийн 4 долоо хоногт ажилгүйдлийн тэтгэмж хүсэгчдийн тоо 22 саяд хүрсэн нь нийт ажиллах хүчний 1/8 юм². Блүүмбергийн шинжээчид АНУ-ын ажилгүйдлийн түвшин 20 хувь давах төсөөлөл улам бодитой болж байгааг онцолжээ. АНУ-ын төсвийн алдагдал 2020 онд 3.8 их наяд ам.доллар давж, улсын өр Дэлхийн II дайнаас хойших хамгийн дээд хэмжээнд хүрэхээр байгааг АНУ-ын төсвийн бодлогын хяналтын хорооноос онцоллоо. АНУ-ын Засгийн газар эдийн засгийг дэмжих арга хэмжээгээ өргөжүүлбэл төсвийн алдагдал, Засгийн газрын өр үргэлжлэн тэлэх хүлээлттэй байна. АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп Мягмар гарагт КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй хөл хориог 5-р сарын 1-ээс өмнө цуцалж эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ гэж мэдэгдлээ.

¹ Maryla Maliszewska, Aaditya Mattoo, Dominique van der Mensbrugghe “[The Potential Impact of COVID-19 on GDP and Trade, A Preliminary Assessment](#)”, April 2020, World Bank Policy Research Working Paper 9211

² [Bloomberg](#): Мужийн төрийн үйлчилгээний байгууллагууд ачааллаа дийлэхгүй байгаа тул зарим өргөдлийг бүртгэж амжаагүй, бодит ажилгүйдэл үүнээс өндөр байж болзошгүй байна.

- КОВИД-19-өөс сэргийлэх хөл хорио ирэх 3 сарын туршид үргэлжлэх тохиолдолд **Их Британийн эдийн засаг II улиралд 35 хувиар агших эрсдэлтэй байгааг** Их Британийн Төсвийн тогтвортой байдлын албанаас мэдэгдлээ. Засгийн газрын зээл 2020-2021 онд 218-273 тэрбум фунт стерлинг хүртэл нэмэгдэж, төсвийн алдагдал нийт ДНБ-ий 14 хувьд буюу Дэлхийн II дайнаас хойших хамгийн дээд түвшинд хүрэхээр байна. Эдийн засгийн салбаруудаас боловсролын салбар 90 хувиар, байр, хоол, хүнс хангамжийн үйлчилгээ 85 хувиар буурахаар байгаа нь хамгийн хүчтэй өртөх салбарууд болж байна.
- ЕИУ байгууллагаас дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ буурсан болон КОВИД-19-тэй холбоотой хорио, цээрийн нөлөөгөөр ОХУ-ын эдийн засаг 2020 онд 2.6 хувиар агших төсөөллийг 4-р сарын 15-нд гаргалаа.
- Европын зарим орнууд КОВИД-19 цар тахлын хөл хориог бүрэн цуцлахгүй хэдий ч, вирусийн дэгдэлтийн оргил үеийг давсан гэж үзэж байгаа тул **зарим эрсдэл багатай салбаруудын үйл ажиллагааг нээж, эдийн засгийг дэмжихээр болжээ**. Испани улс хөл хориогоо эхлүүлснээс хоёр долоо хоногийн дараагаас буюу 4-р сарын 13-аас барилгын салбарын ажилчдын хориогийг цуцлаад байна. Итали улс хөл хориог 5-р сарын 3-ныг хүртэл сунгаж, харин ном, хүүхдийн хувцасны дэлгүүр, хэвлэх үйлдвэр зэрэг зарим үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээж эхэллээ. Франц улс хөл хориог 5-р сарын 11-г хүртэл үргэлжлүүлж, эхний ээлжинд бага, дунд сургуулиудын үйл ажиллагаа эхлэхээр болжээ. Харин ОХУ-д КОВИД-19-ийн тархалт эрчимжиж байгаа тул хөл хориог чангаруулахаар байна.

- Хятадын эдийн засаг энэ оны 4-р сарын 10-ны байдлаар 95 хувийн потенциал түвшнээр ажиллаж байна³. Энэ оны 4-р сарын 1-ний өдрийн байдлаар Хятадын орон сууц, хотын дэд бүтцийн төслүүдийн 80 хувь, жижиг аж ахуйн нэгжүүдийн 80 хувь, хоол хүнсний хангамжийн бизнесүүдийн 85.4 хувь нь үйл ажиллагаагаа сэргээгээд байна⁴. Энэ оны 4-р сарын 9-ний байдлаар Хятадын том аж ахуйн нэгж, компаниудын 90 хувь нь үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Хятадын ган үйлдвэрлэлийн төв Тяньшан дахь гангийн үйлдвэрүүд өмнөх долоо хоногт нь 74.4 хувийн хүчин чадлаар ажиллаж байсан бол 4-р сарын 3-ны байдлаар 76.8 хувь болж нэмэгдлээ⁵. Барилгын салбарт ашиглагдах гангийн худалдаа 4-р сарын 10-ны байдлаар өмнөх долоо хоногоос 24 хувиар өслөө. Түүнчлэн барилгын салбарын идэвхжлийг илэрхийлдэг дохио өгөх үзүүлэлтүүдийн нэг болох экскаваторын худалдаа 3-р сард 49400 хүрч, өмнөх оны мөн үеэс 11.6 хувиар нэмэгджээ. Иймд барилгын салбарын идэвхжил алгуур сэргэх хүлээлттэй байна. Хятадын Аж үйлдвэр, мэдээлэл технологийн яамны мэдээллээр 4-р сарын 6-ны өдрийн байдлаар барилгын салбарын 3.73 сая ажилчин буюу нийт ажилчдын 79 хувь нь ажилдаа эргэн ороод байна. Орон нутгийн хэвлэл мэдээллээр Apple компанийн томоохон ханган нийлүүлэгчдийн нэг болох

³ Блүүмбергийн шинжээчдийн тооцоолол. Уг тооцоололд вирусын голомт Хубэй муж ороогүй болно.

⁴ Хятадын Орон сууц, хот, хөдөөгийн хөгжлийн яамны мэдэгдэл.

⁵ Хятадын Аж үйлдвэр, мэдээлэл технологийн яамнаас энэ оны 3-р сарын 24-ний өдөр хийсэн мэдэгдэл.

Foxconn компанийн ажилчдын 93.7 хувь нь 3-р сарын эцсийн байдлаар ажилдаа эргэн ороод байна гэж мэдээлэв.

- Хятадын эдийн засаг энэ оны эхний улиралд 11%-иар буурах төсөөлөлтэй байсан боловч, -6.8 хувиар буурсан нь хүлээж байснаас бага уналаа. 3-р сард аж үйлдвэрлэл -8 хувь, жижиглэн худалдаа -14 хувь, хөрөнгө оруулалт -13 хувиар тус тус буурах хүлээлттэй байлаа. Хэдийгээр эдийн засаг нийт 95 гаруй хувийн потенциалгаар ажиллаж эхэлсэн ч, Хятадын гадаад эрэлт саарах дарамт 3-р сарын дундаас огцом нэмэгдсэн, цаашид түнш орнуудын КОВИД-19 өвчлөлийг хяналтад оруулах хугацаа уртасч болзошгүй тул сарын тоон мэдээлэл сайжирсан ч, үйлдвэрлэл хэвийн түвшинд бүрэн хүрсэн гэсэн үг биш гэдгийг Үндэсний статистикийн хорооноос нь онцлов. Хөрөнгө оруулалт оны эхний 2 сард өмнөх оны мөн үеэс 24.5 хувиар агшсан бол 3-р сард ажилчид ажилдаа алгуур эргэн орсон нь дэмжлэг болж, эхний улиралд 10.8 хувиар агшсан үзүүлэлттэй гарлаа. Үл хөдлөх салбарын борлуулалт буурсан хэвээр, жижиглэн худалдаа 10 хувийн бууралтаас нэмж буурсан, автомашины борлуулалт 3-р сард өмнөх жилийн түвшнээс 40 хувиар буураад байна.
- Гадаад худалдааны тэнцэл 3-р сард агшсан хэдий ч, төсөөллөөс давсан гүйцэтгэлтэй гарлаа. Хятадын экспорт 3-р сард 6.6 хувиар, импорт 0.9 хувиар буурчээ⁶. Улмаар оны эхний 2 сард 7.1 тэрбумын алдагдалтай гарсан

⁶ Блүүмбергийн шинжээчид 3-р сард Хятадын экспорт 13.9 хувиар, импорт 9.8 хувиар буурахаар төсөөлж байсан.

Хятадын худалдааны тэнцэл 3-р сард 19.9 хувийн ашигтай гарав. Түүнчлэн АНУ-аас импортолсон буурцагны хэмжээ оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өссөн нь Хятадын талаас худалдааны хэлэлцээрийн хэрэгжилтэд анхаарч байгааг илтгэж байна.

- **КОВИД-19 өвчлөлөөс шалтгаалан эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хадгалагдаж** байгааг SXCoal 4-р сарын 15-ны тоймдоо мэдээлэв. Түүнчлэн Хятадын нүүрсний зах зээл 4-р сард ёроолдоо хүрч, 5-р сард тогтворжин, 6-р сараас идэвхжих хүлээлттэй гэсэн байна. Хятадын голлох 4 боомтын нүүрсний нийт нөөц 4-р сарын 15-ны байдлаар 27.2 сая тонн буюу 2018 оноос хойших хамгийн өндөр түвшинд хүрэв. Түүнчлэн нүүрс ашигладаг цахилгаан станцын тоо өмнөх оны мөн үеэс 30 хувиар буураад байна. Үнэ буурсан нөлөөгөөр Австралиас авах коксжих нүүрсний импорт 4-р сарын 1-13-ны хооронд 23 хөлөг онгоц болж, өмнөх сараас 2 дахин нэмэгдлээ. Оны 2-р улиралд дэд бүтцийн төслүүд эхэлснээр гангийн эрэлт нэмэгдэж, Хятадын жилийн үйлдвэрлэл өмнөх оны түвшинд байх хүлээлттэй байна.

- **Хятадын төсвийн бодлого:** Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бонд гаргалт болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авснаар ойролцоогоор 2020 онд 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийхээр байна. Төсвийн дэмжлэгийн нийт хэмжээг тооцоход хангалттай мэдээлэл хараахан гараагүй бөгөөд одоогоор зарлагдаад байгаа мэдээллээр төсвийн дэмжлэг 2020 онд ДНБ-ий 3 хувь буюу 3 их наяд юань хүрэхээр байна. Түр хугацаанд хойшлогдоод буй Ардын Их Хурлаар төсвийн нэмэлт дэмжлэг, арга хэмжээнүүд зарлагдах хүлээлттэй байна.
- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк (ХАБ) 4-р сарын 14-нд 1 жилийн дунд хугацааны зээлийн хүүг 0.2 нэгж хувиар бууруулж 2.95 хувьд хүргэн, 100 тэрбум юанийн эх үүсвэрийг чөлөөлөөд байна. ХАБ энэ онд бодлогын хүүгээ 0.4 нэгж хувиас илүүгүй бууруулахаар байгаа бөгөөд 4-р сарын 20-нд бодлогын хүүг 0.2 нэгж хувиар бууруулах хүлээлт хэвээр байна. Нийгмийн халамжийн санхүүжилтэд 3-р сард 5.15 их наяд юань зарцуулсан бол шинээр олгогдсон зээлийн дүн 2.85 их наяд юань хүрсэн нь 3 дугаар саруудын түүхэн дэх хамгийн өндөр өсөлт болов. Мөн цаашид дунд хугацааны зээлийн хүүг бууруулах, жижиг дунд бизнесүүдэд хөнгөлөлттэй зээлийн нөхцөлийг дэмжих зэрэг арга хэмжээг авах хүлээлттэй байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл:


Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын төлөвлөгөө 94.9%-тай биелж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.1% буурсан байна. 2020 оны 1 дүгээр улирлын төсвийн гүйцэтгэлээр тэнцвэржүүлсэн нийт орлого 2,073.8 тэрбум төгрөг гарсан нь төлөвлөснөөс 5.1%-иар буюу 111.1 тэрбум төгрөгөөр дутсан үзүүлэлт юм.

Хүснэгт 2. Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж, 1 дүгээр улирал

	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын орлого	1,966,863.1	1,912,561.6	(54,301.5)
Татварын бус орлого	218,060.1	161,246.0	(56,814.0)
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламж	2,184,923.2	2,073,807.6	(111,115.6)

Эх сурвалж: Сангийн яам, Монголбанк

Зураг 1. Татварын орлогын задаргаа, сараар




Эх сурвалж: Монголбанк

Татварын орлогын дэлгэрэнгүй задаргааг авч үзэхэд 2020 оны 3 дугаар сард нийт 657.3 тэрбум төгрөгийн татварын орлого бүрдсэний 9% (61.4 тэрбум төгрөг) нь ААНОАТ, 12% (80.9 тэрбум төгрөг) нь ХХОАТ, 24% (160.0 тэрбум төгрөг) нь НДШ, 29% (190.3 тэрбум төгрөг) нь НӨАТ, 25% (164.8 тэрбум төгрөг) нь бусад татварын орлого байна. Үүнээс **ААНОАТ нь өмнөх сараас 3.5 дахин (154.0 тэрбум төгрөг) буурсан** байгаа бол хөрөнгийн албан татвар болон НӨАТ нь харгалзан 2.9 (13.0 тэрбум төгрөг) болон 51.5 дахин (186.6 тэрбум төгрөг) өссөн байна. ААНОАТ-ын хэмжээ ийнхүү буурсан нь бизнесийн идэвхжил суларч байгааг илтгэж байна.

Харин төсвийн нийт зардал өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 19.3%-иар өссөн буюу урсгал зардал 8.3% (164.1 тэрбум төгрөг), хөрөнгийн зардал 43.4% (73.0 тэрбум төгрөг)-иар тус тус өсжээ.

Хөрөнгийн зах:

Зураг 5. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс




Эх сурвалж: Монголбанк

Дэлхийн санхүүгийн зах зээлд коронавирусээс үүдэлтэй эрсдэл, тодорхойгүй байдал нэмэгдсэнээр голлох хөрөнгийн биржийн индексүүд унаад байсан бол сүүлийн 1 сарын хугацаанд бага зэрэг өслөө. Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй багцаа зарж илүү хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөд эх үүсвэрээ байршуулж эхэлснээр **Монгол Улсын Засгийн газар болон компаниудын бондуудын үнэ унаж**, хүү нь 2020 оны 3 дугаар сараас эхлэн огцом өслөө. Хэрэв дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал даамжирвал Монгол Улсын дахин санхүүжилтийн өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна.

Монголын хөрөнгийн захын идэвхжил суларч байна. 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр I, II, III ангиллын 25 хувьцаат компанийн 67,635,006.09 төгрөгийн үнийн дүн бүхий 476,848 ширхэг хувьцаа арилжаалагдсанаас 9 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 10 хувьцаат компанийн хувьцааны ханш буурсан бол 6 үнэт цаасны ханш тогтвортой байлаа. Улмаар ТОП-20 индексийн үзүүлэлт 16712.3 болж оны эхнээс 13.5%-иар буураад байна.


Зураг 6. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

Банкуудын зээлийн тайлан:

Зураг 7. Зээлийн эргэн төлөлт, тэтгэврийн зээлийг хассан /тэрбум төгрөг/



Эх сурвалж: Монголбанк

2020 он гарсаар тэтгэврийн зээлээс бусад зээлийн олголт болон эргэн төлөлтийн хэмжээ буурсан байна⁷. 2019 оны 12 дугаар сард нийт зээлийн үлдэгдэл (тэтгэврийн зээл хассан)-ийн 11.4% буюу 1.97 их наяд төгрөгийн зээлийг эргэн төлсөн байна. Харин 2020 оны 3 дугаар сард энэ үзүүлэлт нь 7.4% болж буурчээ.

Зээл олголтын хэмжээ 2019 оны 12 дугаар сард 1.99 их наяд төгрөг байсан бол, 3 дугаар сард 1.23 их наяд төгрөг болж 38%-иар буурсан байна. Үүнээс иргэдийн зээл 28%-иар, ЖДҮ эрхлэгч ААН-үүдийн зээл 22%-иар буурчээ.

⁷ МУ-ын Засгийн газраас тэтгэврийн зээлийг тэглэсэнтэй холбоотойгоор зээлийн эргэн төлөлтийн хэмжээ 2020 оны 2, 3 дугаар саруудад нэмэгдсэн тул тэтгэврийн зээлийг хасаж тооцов.

2020 оны 3-р сарын 11-ний өдөр Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, (2) төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар бууруулж, 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөх, (3) бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар шинэчлэн тогтоох багц шийдвэр гаргасан.

Харин 3-р сарын 18-ны өдөр банкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д түр хугацааны өөрчлөлт орууллаа. Ингэснээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног болгон уртасгаж, хэрэглээний болон бизнесийн зээлийн гэрээнд бүтцийн өөрчлөлт хийхэд ангиллыг бууруулахгүй байх боломжийг бий болголоо.

Түүнчлэн, 3-р сарын 20-ны өдөр банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авч Төв банкнаас арилжааны банкуудад олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулав. Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай (дахин 6 сараар сунгагдах боломжтой) эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв.

4-р сарын 1-ний өдрөөс эхлэн КОВИД-19 вирусийн халдвараас урьдчилан

сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк санаачлан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд арилжааны банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг бууруулснаар ихэнх банк 20%-иар, зарим банк 100% -иар тус тус бууруулан хэрэгжүүлж байна.

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээлд хамрагдагчдад зориулж Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкууд хамтран дараах шийдвэрийг гаргалаа. Үүнд:

- Орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах;
- Зээлийн эргэн төлөлтөд нь 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш доголдол үүссэн зээлдэгчид энэхүү зохицуулалт үйлчлэх боломжтой бөгөөд доголдол үүссэн хуваарьт өдрөөс эхлэн эргэн төлөлтийг хойшлуулах хугацааг тооцох;
- Зээлдэгч зээлийн эргэн төлөлтөд өөрчлөлт оруулах хүсэлтээ 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харилцагч банкандаа гаргана.

Эдгээр Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны зохицуулалтыг түр хугацаанд зөөлрүүлэх, банкны төлбөрийн чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогын багц арга хэмжээ нь санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд

зогсохгүй КОВИД-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөөтэй.

УИХ-ын чуулганы 4-р сарын 9-ний өдрийн хуралдаанаар иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай хууль, тогтоолын төслүүдийг баталлаа.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзэж эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэхийн зэрэгцээ хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар 1 удаа сунгаж зээлийн сарын эргэн төлөлтийн хэмжээг бууруулах бодлогын багц шийдвэрийг гаргалаа.

Засгийн газрын 4-р сарын 17-ны өдрийн хуралдаанаар, нийгмийн даатгал болон

татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, санхүүгийн дэмжлэг олгохтой холбоотой харилцааг зохицуулсан журмыг баталлаа. Уг журамд ажил нь доголдож борлуулалтын орлого нь багассан ч ажлын байраа хадгалж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд 2020 оны 4 сарын 1-ний өдрөөс 10 сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар зохицуулжээ. Түүнчлэн, 2019 оны тайлангаар 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой ажилласан аж ахуйн нэгжийн 2020 оны 4 сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл олсон үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг чөлөөлөхөөр болсон. Мөн ажил нь зогссон, борлуулалтын орлого нь 50 хувиас дээш хэмжээгээр багассан хувийн аж ахуйн нэгжийн ажилтанд 4 сарын 1-нээс 7 сарын 1 хүртэл сар бүр 200 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор журамд тусгажээ.

ХАВСРАЛТ

Экспортын гол нэрийн түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

	Бодит гүйцэтгэл						Товч тайлбар
	Үнэ 2020/04/14	Өөрчлөлт					
		өдрийн	7 хоног	сарын	оны эхнээс	жилийн	
Зэс	5134	-1.0%	1.8%	-3.7%	-17.5%	-21.2%	КОВИД-19-ийн тархалт АНУ, Евро бүсийн орнуудад нэмэгдсэн нөлөөгөөр зэсийн эрэлт саарахаар байна. Гэсэн хэдий ч Хятадын үйлдвэрлэлийн салбар 95%-ийн потенциалгаар ажиллаж байна гэсэн мэдээ үнэ өмнөх долоо хоногоос нэмэгдэхэд голлон нөлөөлөв.
Коксжих нүүрс	136	-	-	-	-	-34.3%	КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөвтэй. Хятадын голлох цахилгаан станцуудын нөөц 31 өдөр хүрч нэмэгдсэн, Австралийн нийлүүлэлт тогтвортой байна.
Төмрийн хүдэр	83.4	0.0%	0.4%	-1.3%	-9.8%	-5.5%	Хятадын аж үйлдвэрлэлийн эрэлт буурахаар байгаа ч алгуур сэргэх хүлээлттэй. Нийлүүлэлт талаас илүү хувийг бүрдүүлдэг Австралийн нийлүүлэлт тогтвортой байна.
Алт	1726.97	-0.6%	2.0%	13.4%	12.4%	34.8%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт нэмэгдэхээр байна.
Газрын тос (Брент)	29.6	-6.5%	-12.0%	-7.9%	-58.2%	-61.1%	КОВИД- 19-ийн нөлөөгөөр эрэлт огцом буурч, Сауди Араб, ОХУ-ын үйлдвэрлэлээ нэмэгдүүлэхээр байсан бол ОПЕК-ийн нэгдэл нийлүүлэлтээ бууруулахаар байгаа ч энэ нь хангалттай биш байгаагаас үнэ өмнөх долоо хоногоос буурахад голлон нөлөөлөв.